



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 05 сарын 21 өдөр

Дугаар А/64

Жаргалтхаан сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн 03 тоот тогтоолын 1 дүгээр хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд зохиогдож буй “Мал аж ахуйн үйлдвэрлэл эрхлэгчдийн чуулга уулзалт”-ыг зохион байгуулахад малчдад зориулсан сургалт сурталчилгааны зардалд зориулж 3,000,000 (гурван сая) төгрөгийг зарцуулсугай.

2. Дээрх зардалд шаардагдах 3,000,000 (гурван сая) төгрөгийг сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн зардлаас гаргахыг Засаг даргын Тамгын газрын дарга С.Мөнхдэлгэр, нягтлан бодогч Э.Эрдэнэхүү нарт зөвшөөрсүгэй.

3. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг сумын Засаг даргын орлогч (Н.Отгонбаяр)-т даалгасугай.

ДАРГА  С.ГАНБАТ